



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайншагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН  
ЗАСАГ ДАРГА  
М.БАЯРСҮХ ТАНАА

2023. 03. 28 № 140

тавай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын багалсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг ошолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 313.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч, 2,140.0 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлж холбогдох хууль, журмын дагуу бүртгэл тайланд тусгасан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

**Аудитын гол асуудал**

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Засаг даргын Тамгын газар нь аймгийн Засаг даргын 2022 оны Б/333 дугаар бүхий үндэслэлгүй захирамжаар төсвийн ерөнхийлөн захирагчид балансын урамшуулал олгосон, төсөл хэрэгжүүлэгч 2 иргэн үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн зорчил нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг буруу тайлагналын эрдэл өндөр үнэлэгдсэн асуудал байлаа.

**Бусад асуудлын хэсэг**

012020273

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 28 зорилт, 105 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 99.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ